

ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Эдийн Засгийн Сургуулиас эрхлэн гаргадаг “ЭДИЙН ЗАСАГ: онол практик ” сэтгүүлийн 25 дахь дугаарыг Та бүхэндээ толилуулж байна.

Энэ удаагийн дугаарт нийтлэгдэж байгаа өгүүлүүд нь эдийн засаг, менежмент, санхүү,банк, маркетингийн салбар дахь анхаарлын төвд байгаа сонирхолтой бөгөөд шийдвэр хүлээгдэж буй асуудлуудыг авч үзсэнээр онцлог юм.

Өнөөгийн нөхцөлд шинэ, хуучин эдийн засгийн тухай шилжилтийн үе дууссан эсэх тухай асуудал нь олон нийтийн анхаарлыг татсан. шинжлэх ухааны үндэслэлтэй хариулт шаардсан,тулгамдсан асуудлын нэг билээ. Энэ тухай академич, профессор П.Лувсандорж гуайн бичсэн ”Шинэ хуучин эдийн засаг, шинжээчдийн шинэ үе” өгүүллээс уншаарай. Мөн манай орны эдийн засагт шинэ үеийг нээж байгаа уул уурхайн үйлдвэрлэлийн талаар доктор Н.Болорын “Уул уурхайн хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ”, доктор Ч.Ундрамын “Уул уурхайн төслийг хэрэгжүүлэхэд симуляци дүн шинжилгээний аргыг хэрэглэх нь” нийтлэлүүдээс, Эх орны хишиг-эрдэний хувийн эдийн засагт үзүүлэх нөлөөний талаар докторант Д.Ган-Очирын “Монголын инфляцийн бүтцийн загвар” өгүүллээс сонирхоорой.

Орчин үеийн менежментийн сонирхолтой асуудлуудын талаар доктор, Б.Болор, Ц.Цэвээн докторант Д.Энх-Отгон, дэд профессор Н.Лизунов нарын бичсэн өгүүллээс, санхүү, банк, маркетингийн асуудлаар хийсэн шинжилгээний дүнг докторант Г.Амарбаясгалан, С.Бурмаа нарын нийтлэлээс сонирхон уншаарай.

“Дэлхийн эдийн засгийн хямралын анхдагч шалтгаан өгүүллийг Р.Батжаргал докторант Д.Хишгээ нар орос хэлнээс эх хэлнээ хөрвүүлэн уншигч танд толилуулж байна.

Академич П.Лувсандорж
Профессор Б.Сувд

Зохиогчид

П.Лувсандорж. Монгол Улсын ШУ-ны Академийн гишүүн (Академич) МУИС-ийн ЭЗХ-ийн захирал, Эдийн засгийн ухааны доктор, профессор Судалгааны чиглэл: “Хөгжлийн эдийн засаг”, “Шилжилтийн эдийн засаг” Сүүлийн үеийн бүтээл “Хүний хөгжлийг дэмжих эдийн засгийн бодлого” 2008

Д.Ган-Очир. Австралийн их сургуульд докторант, МБ-ны судалгааны газарт эдийн засагч. Сүүлийн бүтээл “Таамаглалын тодорхой бус байдал: Инфляцийн таамаглалын нарийвчлалд үндэслэсэн шинжилгээ”, “Монголын эдийн засаг дахь мөнгөний бодлогын индекс (МСИ)-ийн тооцоо: Мөнгөний бодлого / зөөлөрч чангарч /байна уу ? ” ЭЗ-ийн онол,практик сэтгүүл. 2009 № 321(23).2010/329/

Н.Болор. Доктор PhD. МУИС-ийн ЭЗС-ийн менежментийн тэнхимийн багш. Судалгааны чиглэл: “Хөгжлийн эдийн засаг, өрсөлдөх чадварын эдийн засаг, уул, уурхайн эдийн засаг.

Н.Лизунов. Дэд профессор МУИС-ЭЗС-ийн Менежментийн тэнхимийн багш. Судалгааны ажлын чиглэл нь “Үйлдвэрлэлийн менежмент

Ч.Ундрам: Доктор, дэд профессор, МУИС-ЭЗС-ийн Менежментийн тэнхимийн эрхлэгч . Судалгааны чиглэл: Уул уурхайн төслийн менежмент, Уул уурхайн бизнес менежмент, Симулиац дүн шинжилгээ. Сүүлийн бүтээл: Германы Холбооны Улсын VDM Publishing House Ltd. хэвлэлийн компанийн хүсэлтээр эдийн засгийн ухааны докторын зэрэг горилсон диссертацийн ажлыг ном болгон “Project Management and Simulation Analysis in the Mining Industry: Theory and Practice” нэрээр хэвлүүлсэн, (2010 он) VDM Publishing House Ltd., Mauritius, ISBN 978-3-639-08546-4.

Ц.Цэвээн, Доктор, профессор, **Д.Энх-Отгон.** докторант МУИС-ийн ЭЗС-ийн Менежментийн тэнхимийн багш. Судалгааны чиглэл: Монголын хөдөө аж ахуй, Монголын эдийн засгийн түүхийн асуудлууд.

С.Бурмаа. МУИС-ЭЗС-ийн докторант Судалгааны чиглэл: “Жижиглэн худалдааны барааны нөөцийн удирдлага” 321/23

Г.Амарбаясгалан. МУИС-ЭЗС-ийн докторант .Өвөрхангай Монгол банкны салбарт мэргэжилтэн. Судалгааны чиглэл: Мөнгөний бодлого. Бүтээл Санхүүгийн зуучлагчийн түүхэн замнал” 2004 он

Д.Хишгээ. Докторант МУИС-ЭЗС-ийн ЭЗО-ын тэнхимийн багш. Судалгааны чиглэл : “Хөрөнгө оруулалт” Сүүлийн үеийн бүтээл : “Хүмүүн капиталын хөрөнгө оруулалтыг онолын асуудалд” Эдийн засгийн онол практик сэтгүүл: 2008 он № 299/19 дугаарт хэвлэгдсэн.

Р.Батжаргал. “Сити ДС ийн” ЭЗБУ- гийн тэнхимийн багш.